

Химийн бодисын ашиглалт, хадгалалт, аюултай хог  
хаягдлын менежментийг сайжруулах талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, гишүүд  
“Химийн бодисын ашиглалт, хадгалалтын өнөөгийн байдал, тулгамдсан  
асуудлууд”-ын тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн  
бичгийн дарга Ц.Энхтүвшингийн илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Улсын Их Хуралд:

1.Химийн хорт болон аюултай бодис, аюултай хог хаягдлын зохистой  
менежментийг бүрдүүлж, байгууллага хоорондын ажлын уялдаа болон хор  
хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах зохицуулалт хийх,  
хяналтыг чангатгах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр  
эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Хоёр. Засгийн газарт:

1.Химийн бодис, аюултай хог хаягдлын менежментийн үндэсний хөтөлбөр  
боловсруулан баталж хэрэгжүүлэх /2012 оны 3 дугаар улиралд багтаан/;

2.Аюултай хог хаягдал , химийн хорт болон аюултай бодисын хаягдлын  
асуудлаарх салбар дундын зохицуулалтыг боловсронгуй болгож, хяналтын болон  
судалгаа шинжилгээ, авран хамгаалах байгууллагын чадавхийг бэхжүүлэх / 2012  
оны 3 дугаар улиралд багтаан/;

3.Аюултай хог хаягдлыг устгах, аюулгүй болгох зориулалтын байгууламж  
байгуулах асуудлыг байгаа бололцоогоо ашиглан 2012 оны эхний хагас жилд  
багтаан эхлүүлэх арга хэмжээ авах. Зориулалтын байгууламж баригдаж  
ашиглалтад орох хүртэлх хугацаанд химийн хорт хаягдлыг түр хадгалах  
зориулалтын байр нэгдсэн агуулахын асуудлыг шийдэж, харуул хамгаалалтыг  
сайжруулах;

4.Химийн бодис, аюултай хог хаягдлын талаархи мэдээллийг шуурхай  
дамжуулах, солилцох нөхцөлөөр хангах мэдээллийн нэгдсэн цахим санг  
боловсронгуй болгон бүрдүүлж, төв, орон нутгийн байгууллагыг холбож ашиглах;

5.Химийн бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүний хор аюул, аюулгүй хэрэглээ, аюултай хог хаягдлын талаархи бүх нийтийн боловсрол, мэдлэг олгох сургалт сурталчилгааг эрчимжүүлэх.